

Хотын бие тамир спортыг удирдах төв байгууллага

1924 онд залуучуудын эвлэлийн төв хороонд биеийн тамирыг сайжруулах хэлтэс байгуулсан. 1930-11-18-нд Гэгээрлийн яамны дэргэд биеийн тамирын боловсролын зөвлөл байгуулсан юм.

1932-7-28-нд мөн зөвлөлийг татан буулгаж, түүний үүргийг Сайд нарын Зөвлөлд шилжүүлж, олон нийтийн байгууллагад эрхлүүлжээ.

1957-3-7-нд Сайд нарын Зөвлөлийн 145 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын захиргаанд Улаанбаатар хотын биеийн тамир, спортын асуудлыг эрхлэх биеийн тамирын хороог 2 оронтой тоотойгоор байгуулж сарын цалингийн фондыг 1350 төгрөгөөр баталжээ.

1960 онд Улаанбаатар төмөр замын газар бөхийн чөлөөт барилдааны бүлгэм байгуулж хичээллэсэн нь манай оронд биеийн чөлөөт барилдааны үүсч хөгжихийн эхлэл болжээ.

1965-10-6-нд Сайд нарын Зөвлөлийн 361 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын биеийн тамир, спортын эвлэлийн нийгэмлэгүүдийг удирдах товчоог татан буулгаж, Улаанбаатар хотын биеийн тамир, спортын эвлэлийн зөвлөл байгуулахаар тогтоожээ

1974-6-14-нд Сайд нарын Зөвлөлийн 234 дүгээр тогтоолоор Төв цэнгэлдэх хүрээлэнг биеийн тамир, спортын эвлэлийн төв зөвлөлөөс Улаанбаатар хотын захиргааны мэдэлд шилжүүлсэн.

1979-2-7-нд БНМАУ-ын биеийн тамир спортын төв зөвлөлийг өөрчлөн БНМАУ-ын биеийн тамир спортын төв зөвлөлийг өөрчлөн БНМАУ-ын биеийн тамир, спортын хороо байгуулсантай холбогдуулан аймаг, хот, районы биеийн тамирын нийгэмлэгүүдийг биеийн тамир, спортын хороо болгон өөрчилж, түүнд спорт, клуб, хамтлаг байгуулах нь зүйтэй гэжээ. шилжүүлжээ.